



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Алба, зөвлөл, хороо, багийг
шинэчлэн байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8 дахь хэсэг, 34 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3 дахь хэсэг, 31 дүгээр зүйл, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 20 дугаар зүйлийн 20.2, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 344, 2017 оны А/43, 2019 оны 536, мөн оны 565, мөн оны 566 дугаар тушаал, Архивын Ерөнхий газрын даргын 2007 оны А/59 дүгээр тушаалын 2.2.2, 2.2.4 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/256 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/445 дугаар тушаал, 2021 оны А/331 дүгээр тушаал, 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 1а/2732 дугаар албан бичиг, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.3.1 дэх хэсэг, Монгол улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоол, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/470 дугаар тушаалын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Үндэсний төвийн үйл ажиллагааны үр дүн, чанарыг дээшлүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Тус төвийн Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, Тохиолдлын удирдлагын тогтолцооны штабын удирдах бүрэлдэхүүнийг 3 дугаар, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 4 дүгээр, Чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус албаны бүрэлдэхүүнийг 5 дугаар, Баримт бичиг нягтлан шалгах байнгын комиссын бүрэлдэхүүнийг 6 дугаар, Цацрагийн аюулгүйн албаны бүрэлдэхүүнийг 7 дугаар, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын бүрэлдэхүүнийг 8 дугаар, Тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах сэргийлэх багийн бүрэлдэхүүнийг 9 дүгээр, Үйлчилгээний санал, өргөдөл, гомдлыг шалган бүртгэх багийн бүрэлдэхүүнийг 10 дугаар, Сэтгэлд нийцсэн үйлчилгээний багийн бүрэлдэхүүнийг 11 дүгээр, Чанарын менежмент, эрсдлийн удирдлагын багийн бүрэлдэхүүнийг 12 дугаар, Халдварын сэргийлэлт, хяналтын багийн

1309010031

бүрэлдэхүүнийг 13 дугаар, Мэдээллийн аюулгүй байдлын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 14 дүгээр, Сувилахуйн албаны бүрэлдэхүүнийг 15 дугаар, Ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүнийг 16 дугаар, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 17 дугаар, Жендерийн дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг 18 дугаар, Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 19 дүгээр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 20 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Ерөнхий захирлын 2021 оны А/24, 2022 оны А/03, А/30, 2023 оны А/65 дугаар тушаалуудыг хүчингүйд тооцсугай.

3. Алба, зөвлөл, хороо, багийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан 2024 оны 01 дүгээр сард багтаан төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнахыг алба, зөвлөл, хороо, багийн дарга, ахлагч, нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /С.Алтаннамар/-т даалгасугай.


5. Энэ тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн
А/03 дугаар тушаалын 10 дугаар хавсралт



Үйлчилгээний санал, өргөдөл, гомдлыг шалган бүртгэх
багийн бүрэлдэхүүн

Ахлагч:	Ерөнхий захирал	Н. Эрдэнэбаяр
Гишүүд	Захиргаа, маркетингийн албаны дарга Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга	Ч.Батболд
Нарийн бичгийн дарга	Цусны чанар, аюулгүй байдлын албаны Дотоод аудитор	С.Алтанамар